



САНГИЙН ЯАМ



THE WORLD BANK
IBRD • IDA | WORLD BANK GROUP



ОРОН НУТГИЙН
ХӨГЖЛИЙН
САН



ОРОН НУТГИЙН
ХӨГЖЛИЙН
САН



Өвөрхангай аймгийн
Бүрд сумын 2022 оны
“Орон нутгийн
хөгжлийн сан”-ийн
тайлан, 2023 оны
ТӨЛӨВЛӨЛТ

Орон нутгийн хөгжлийн сан гэж юу?

ОНХС-ийн зорилго: *Орон нутгийн хөгжлийг дэмжих, бус нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэнэ.*

Иргэдийн оролцоотой орон нутгийн хөгжлийн асуудлыг шийдвэрлэх:



- **Иргэдийн оролцоо** гэдэг нь аливаа асуудлыг шийдвэрлэхэд дуу хоолой, өөрийн санал бодлоо хэлэх, хийж бүтээх гэсэн бүтээлч үйл ажиллагаа.
- **Иргэдийг оролцуулах нь** гэнэтийн, тохиолдлын үйл явдал бус харин зохион байгуулалттай тасралтгүй үйл ажиллагаа байдаг.

- Төсвийн тухай хууль
- ОНХС-ийн үйл ажиллагааны журам

2013-2021 оны улсын хэмжээнд ОНХС-ийн гүйцэтгэл /урамшуулал, дэмжлэг багтсан/



ОНХС-д хамаарах чиг үүргүүд




Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний хүрээнд:



- Барилга байгууламж, их засвар



- Тоног төхөөрөмж



- Дэд бүтцийг сайжруулах
- МАА, бэлчээрийн менежментийг сайжруулах
- Бусад /Хууль, журамд заасан/

2017-2021 онд сумдын ОНХС-д олгосон “урамшуулал”, “дэмжлэг”-ийн хэмжээ


“Тогтвортой амьжиргаа-3” төслийн “Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ”-нд суурилсан “урамшуулал”

2017 154 суманд 7,2 тэрбум ₮	2018 165 суманд 0,9 тэрбум ₮	2019 222 суманд 4,6 тэрбум ₮	2020 248 суманд 6,5 тэрбум ₮	2021 225 суманд 6,5 тэрбум ₮	2022 215 суманд 7 тэрбум ₮
------------------------------------	------------------------------------	------------------------------------	------------------------------------	------------------------------------	----------------------------------

“Тогтвортой амьжиргаа-3” төслөөс сумдын ОНХС-ийн төсвийг нэмэгдүүлэх зорилгоор бүх суманд олгож байсан санхүүгийн “**ерөнхий дэмжлэг**” /2022 оноос дэмжлэг олгохгүй/

2018 330 суманд 16,3 тэрбум ₮	2019 330 суманд 10,9 тэрбум ₮	2020 330 суманд 3,5 тэрбум ₮	2021 330 суманд 2,5 тэрбум ₮
-------------------------------------	-------------------------------------	------------------------------------	------------------------------------

2016-2021 оны ОНХС-г үнэлдэг ЖГҮ-ий 330 сумын дундаж оноо



2016 оноос жил бүр сумдын ОНХС-г үнэлэхэд бүх сумын дундаж оноо жил бүр өссөн үзүүлэлттэй байв. Үнэлсэн жилийн дараа онд болзол хангасан сумдад “урамшуулал” олгодог.

2022 буюу өнгөрсөн онд хийсэн хөрөнгө оруулалтын тайлан

- СӨББайгууллагын гаднах тоглоомын талбайн тохижилт хийснээр цэцэрлэгийн насны хүүхдүүд цэвэр агаарт чөлөөт цагаа зөв өнгөрөөх нөхцөл бүрдлээ.

Төсөвт өртөг: 20.0 сая төгрөг

Гүйцэтгэгч: С. Өсөхбаяр ахлагчтай “Өсөх-Ирээдүй” бүлэг



- ЕБСургуулийн гаднах биеийн тамирын талбай шинээр баригдсанаар хичээлийн сургалтын чанарыг сайжруулах, сурагчдын бие бялдрыг хөгжүүлэх болон чөлөөт цагаа зөв өнгөрөөх нөхцөл бүрдлээ.

Төсөвт өртөг: 12.0 сая төгрөг

Гүйцэтгэгч: Т. Отгонбаатар ахлагчтай “Үнэмч” бүлэг



2022 буюу өнгөрсөн онд хийсэн хөрөнгө оруулалтын тайлан

- Сумын төвийн Чигчий хорооллын гэрэлтүүлэг хийснээр иргэд ая тухтай таатай эрсдэлгүй орчинд амьдрах таатай нөхцөл бүрдлээ.

Төсөвт өртөг: 10.0 сая төгрөг

Гүйцэтгэгч: Т. Отгонбаатар ахлагчтай “Үнэмч” бүлэг



- Орон нутгийн музей засварын ажил хийгдсэнээр барилгын өнгө үзэмж сайжирч иргэдэд ая тухтай үйлчилгээ авах боломж бүрдлээ.

Төсөвт өртөг: 7.6 сая төгрөг

Гүйцэтгэгч: Иргэн Б. Энхсугар



2022 буюу өнгөрсөн онд хийсэн хөрөнгө оруулалтын тайлан

- Соёлын төвийн хайс шинээр барих ажил хийгдсэнээр орчны тохижилт болон газар ашиглалт сайжирсан.

Төсөвт өртөг: 10.0 сая төгрөг

Гүйцэтгэгч: С. Өсөхбаяр ахлагчтай “Өсөх-Ирээдүй” бүлэг



- Сумын цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт хийж усан оргилуур болон гэрэлтүүлэг ашиглалтад орлоо.

Төсөвт өртөг: 9.0 сая төгрөг

Гүйцэтгэгч: С. Өсөхбаяр ахлагчтай “Өсөх-Ирээдүй” бүлэг



2022 буюу өнгөрсөн онд хийсэн хөрөнгө оруулалтын тайлан

- Хортон мэрэгч устгах ажил хийснээр бэлчээрийн хортон мэрэгч тархсан талбайн хэмжээ буурч сумын хэмжээнд бэлчээр, хадлангийн ургац нэмэгдэж, малын тэжээлийн нөөц бүрдэх нөхцөл бүрдлээ.

Төсөвт өртөг: 26.9 сая төгрөг

Гүйцэтгэгч: “Шим” ХХК



- Малын тэжээлийн ургамал тариалах тоног төхөөрөмж худалдан авснаар малчид өөрсдийн хөдөлмөрөөр хямд өртгөөр тэжээлээ тарьж бэлтгэн тэжээлийн нөөц бүрдэх таатай нөхцөл бүрдлээ.

Төсөвт өртөг: 139.5 сая төгрөг

Гүйцэтгэгч: “Техникхаус” ХХК



2022 буюу өнгөрсөн онд хийсэн хөрөнгө оруулалтын тайлан

- Хүүхдийн тоглоомын талбай барих ажил хийгдсэнээр хүүхдүүд чөлөөт цагаа найзуудтайгаа зөв боловсон өнгөрөөж аюулгүй байдлын хүрээнд 4 ш гэрэл, 2 ш камер суурилуулсан.

Төсөвт өртөг: 20.0 сая төгрөг

Гүйцэтгэгч: С. Өсөхбаяр ахлагчтай “Өсөх-Ирээдүй” бүлэг



2023 буюу энэ онд хийгдэхээр батлагдсан хөрөнгө оруулалтын жагсаалт

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил		Эхлэх, дуусах хугацаа	Төсөвт өртөг	2023 онд санхүүжих дүн /мянган төгрөг/
	1. Шилжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээ	I			254,887.4
	Орон нутгийн хөгжлийн сан				99,687.4
1.1	Иргэний танхим 2-р баг /60622.0/	1	2023	86,773.0	86,773.0
1.1	Газар зүйн нэрийн зураг	2	2023	12,914.4	12,914.4
	Малын тоо толгойн албан татварын эх үүсвэр				155,200.0
1.2	Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах /Худаг 3ш/	3	2023	75,000.0	75,000.0
1.3	МЭТасгийн тоног төхөөрөмж	4	2023	20,000.0	20,000.0
1.4	Зохиомол хээлтүүлгийн багаж хэрэгсэл худалдан авах	5	2023	5,000.0	5,000.0
1.5	Малын тэжээлийн ургамал тариалах тоног төхөөрөмж	6	2022-2023	139,500.0	55,200.0

2. Шинээр эхлэх хөрөнгө оруулалт	II	2023		263,373.0
Орон нутгийн хөгжлийн сан		2023		168,373.0
2.1 Сумын төвийн хогийн цэгийг хашаажуулах	7	2023	20,000.0	20,000.0
2.2 Сумын төв доторх нийтийн эзэмшлийн гэрэлтүүлэгийн урсгал засвар, ногоон байгууламжийн арчилгаа, хог хаягдлыг цуглуулах зайлуулах ажил	8	2023	20,000.0	20,000.0
2.3 СӨББ-ын гал тогооны тоног төхөөрөмж шинэчлэх	9	2023	20,000.0	20,000.0
2.4 Багийн иргэний танхимийн засвар 1-р баг	10	2023	20,000.0	20,000.0
2.5 Багийн иргэний танхим 3-р баг	11	2023	86,773.0	86,773.0
2.6 Зураг төслийн ажил	12	2023	1,600.0	1,600.0
3. Малын тоо толгойн албан татварын эх үүсвэр	III	2023		95,000.0
3.1 Хортон мэрэгч устгал	13	2023	20,000.0	20,000.0
3.2 Гүний худаг гаргах болон засварлах	14	2023	75,000.0	75,000.0
Нийт Орон нутгийн хөгжлийн сан				268,060.4
Нийт малын тоо толгойн албан татварын эх үүсвэр				250,200.0
4.	НИЙТ			518,260.4

**ИРГЭД ОНХС-ИЙН ТӨСВӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ЯМАР САНАЛ
ГАРГАЖ **БОЛОХ** ВЭ?**

ОНХС-ийн хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх үндсэн нөхцөл

- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны **хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан** байх;
- Тухайн орон нутгийн **иргэдийн саналаар дэмжигдэж** эрэмбэлэгдсэн байх;
- Хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад **холбогдох зөвшөөрөлтэй** байх;
- Сум, дүүргийн төвөөс **алслагдсан баг, хорооны иргэдийн хамгийн олон саналыг авч** эрэмбэлэгдсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг **заавал багтаах**;



ОНХС-ийн санхүүжүүлэх чиг үүрэг

Аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүрэг

- Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэх ухаан, цахим технологи;
- Дэд бүтцийг сайжруулах, зам гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ;
- Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах;
- Ундны усны хангамж, эрүүл ахуйг сайжруулах;
- Аймаг, хотын хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн техник эдийн засгийн үндэслэл (цаашид ТЭЗҮ гэх), зураг төсөв боловсруулах;
- Аймгийн бэлчээрийн менежмент болон мал сүргийн чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг нэмэгдүүлэх
- Өрхийн орлогыг дэмжих чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт
- Ажлын байр бий болгох.

Сум, дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүрэг

- Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, инновац, шинжлэх ухаан, цахим технологи;
- Дэд бүтцийг сайжруулах, зам гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ;
- Орчны тохижилт, ногоон байгууламжийг сайжруулах, байгаль орчныг хамгаалах;
- Ундны усны хангамж, эрүүл ахуйг сайжруулах;
- Сум, дүүргийн хөгжлийн төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах;
- Мал аж ахуйг хөгжүүлэх, бэлчээрийн менежментийг сайжруулах;
- Өрхийн орлогыг дэмжих чиглэлээр иргэдийг чадавхжуулах сургалт;
- Ажлын байр бий болгох;
- Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх сургалт, сурталчилгаа.

Малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүрэг

- Бэлчээрийн менежментийг сайжруулах;
- Бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх;/хөдөөгийн хүн, малын усан хангамжийг нэмэгдүүлэх, хөв цөөрөм, далан байгуулах, булгийн эхийг хашиж хамгаалах/
- Малын эрүүл мэндийг хамгаалах;
- Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх;
- Малын чанарыг сайжруулах;
- Гэмт халдлага, гамшгаас хамгаалах;
- Хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх;
- Малын тэжээлийн ургамал тариалах;
- Тэжээлийн нөөц бүрдүүлэх;
- Байгаль орчныг хамгаалах;
- Хортон мэрэгчидтэй тэмцэх/байгаль орчин, хүн, мал, амьтанд халгүй дэвшилтэт арга, технологи ашиглах/;
- Малчдад зориулсан сургалт, сурталчилгаа.

ИРГЭД ОНХС-ИЙН ТӨСВӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ ЯМАР САНАЛ
ГАРГАЖ **БОЛОХГҮЙ** ВЭ?

ОНХС-ийн төсвөөр санхүүжүүлэхийг хориглосон чиг үүрэг



1. Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ.
2. Улс төрийн нам, төрийн бус байгууллагын зарлага;
3. Үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардал;
4. Нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа;
5. Зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа гаргах, хохирлыг нөхөн төлөх үүрэг авах;
6. Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ.

ИРГЭН ХЭРХЭН САНАЛАА ӨГӨХ ВЭ?

ОНХС-ийн үе шатууд



6. Бүх үе шатанд иргэд мэдээлэл авах болон иргэдийн оролцоотой хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх эрхтэй. ЗДТГ, ИТХ, баг/хорооны ЗД мэдээллээр хангах, ХШҮ-нд оролцуулах үүрэгтэй.



ОНХС-ийн үе шатуудад иргэд оролцох боломж:

Иргэдийн оролцоо						
№	Оролцооны хэлбэр/ ОНХС-ийн үе шат	Саналаа өгөх	Эрэмбэлэхэд оролцох	Мэдээлэл авах	Хянах, үнэлэх	Биечлэн оролцох
1	Төлөвлөлт	✓	✓	✓	✓	✓
2	Төслийн эрэмбэлэлт		✓	✓	✓	✓
3	Хэрэгжилт, худалдан авах ажиллагаа			✓	✓	✓
4	Хяналт шинжилгээ үнэлгээ			✓	✓	✓
5	Хөрөнгийн удирдлага			✓	✓	✓

1. Санал өгөх үе шат

2. Бүлгийн ярилцлага /бүлгийн ярилцлагын нэвтрүүлэг үзэх/



1. Санал
асуулгын хуудас
бөглөх

3. Цахим
/аппликэйшн/

Бүх саналуудыг баг/хорооны Засаг дарга нэгтгэж ОНХС-ийн санал эрэмбэлэн, батлах ИНХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлтгэнэ.

Санал асуулгын хуудас бөглөх /ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 1-р хавсралт/

Баг/хорооны Засаг дарга жил бүр 1-6 дугаар сард иргэдээр бөглүүлж авна.



Сум/дүүргээс санал болгох хөрөнгө оруулалтыг бичдэг. Иргэн **дэмжих** бол **Тийм** гэсэн хэсгийг чагтална. **Дэмжихгүй** бол **Үгүй** гэж тэмдэглэнэ.



Иргэн **өөрийн саналыг шинээр** бичнэ.



Малын тоо толгойн албан татвараар хэрэгжүүлэх саналыг бичнэ.



1 дүгээр хавсралт

ИРГЭДЭЭС САНАЛ АВАХ МАЯГТ Саналын хуудасны бүртгэлийн №.....

*18-аас дээш насны иргэн бөглөнө. Хүйс: эр эм

Аймаг/Нийслэл Сум/Дүүрэг..... Баг/Хороо.....

Гэрийн хаяг:хаягт оршин сууховогтой...../регистер №...../ **Та** "Орон нутгийн хөгжлийн сан" /цаашид ОНХС гэх/-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ/цаашид **төсөл** гэх/-ий талаар саналаа өгнө үү.

1. Сум/дүүргийн хөгжлийн бодлого, төлөвлөлттэй уялдуулан сум/дүүргийн ЗДТГ-аас санал болгож буй дараах төслүүдийг дэмжиж байгаа эсэхээ хүснэгтэд тэмдэглэнэ үү.

Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэр	Төсөл хэрэгжих байршил, хүчин чадал	Дэмжиж байгаа бол ТИЙМ	Дэмжихгүй байгаа бол ҮГҮЙ
1.1 /ЗДТГ-аас санал болгож буй төсөл/			
1.2.....			
1.3.....			

Нэмэлт тайлбар:

2. Та амьдарч буй сум/дүүрэг, баг/хороогоо хөгжүүлэх төслийн саналаа бичнэ үү.

Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэр	Төсөл хэрэгжих байршил, хүчин чадал	Үр ашиг хүртэгчдийн тоо
2.1 /Иргэний санал – 1/		
2.2 /Иргэний санал – 2/		
2.3		
2.4		

3. Та Малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр хийгдэх төслийн саналаа бичнэ үү.

Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга	Төсөл хэрэгжих байршил,	Үр ашиг хүртэгчдийн тоо

хэмжээний нэр	хүчин чадал	
3.1 /Санал-1/		
3.2 /Санал-2/		
3.3		
3.4		

..... онысарын..... өдөр

Иргэнд үлдэх хэсэг : Саналын хуудасны бүртгэлийн №.....

Саналын хуудас хүлээн авсан хүний овог, нэр	Хүлээлгэн өгсөн Баг/хорооны Засаг даргын овог, нэр	Огноо
.....оны.....сарын.....өдөр

Тэмдэглэл: Таны болон танай баг/хорооны иргэдийн гаргасан саналыг эрэмбэлж нэгтгэноны сарын..... -ны өдөр баг/хорооны ИНХ-аар хэлэлцэж батлах тул ИРГЭН ТА хуралдаа идэвхтэй оролцоно уу.

Жич: Та нэгдмэл сонирхолтой иргэдтэй бүлэг болж саналаа нэгтгэн баталгаажуулсан тохиолдолд таны/ танай бүлгийн санал олонхын саналаар дэмжигдэн дээгүүр эрэмбэлэгдэх давуу талтай.

ОНХС-ийн санал хэлэлцэн, батлах **ИНХ-ын товыг** бичсэн байдаг.

Бүлгийн ярилцлага хийх



- Иргэд сайн дураар нэгдэж **1-6 дугаар сард** багтаж ИНХ-ын хуралдаан хуралдахаас өмнө хийнэ;
- **Хорооны хувьд 50-аас доошгүй /дүүргийн төвөөс алслагдсан хорооны хувьд 30-аас доошгүй/ иргэн;**
- **Багийн хувьд 30-аас доошгүй /сумын төвөөс алслагдсан багийн хувьд 20-аас доошгүй/ иргэний бүрэлдэхүүнтэй бүлгийн ярилцлагыг зохион байгуулна;**
- ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 3 дугаар хавсралтад заасан **хэлэлцүүлгийн тэмдэглэлд** тусган оролцсон иргэдийн баталгаажуулна; **гарын үсгээр**
- Тэмдэглэлийг баг/хорооны **Засаг даргад гардуулж** өгнө;
- Бүлгийн ярилцлагад албаны хүнийг урьж оролцуулж ОНХС-ийн танилцуулга сонсож болно.

3 дугаар хавсралт

Нээлттэй хэлэлцүүлэг, бүлгийн ярилцлагын маягт

.....аймаг/нийслэлийн..... сум/дүүргийн.....баг/хорооны
бүлгийн "Орон нутгийн хөгжлийн сан"-ийн хөрөнгөөр онд хэрэгжүүлэх төслийн саналын жагсаалт:

Санал асуулгын хэлбэр:/дугаарыг тэмдэглэнэ/

1. Хэлэлцүүлэг
2. Бүлгийн ярилцлага

Оролцсон хүний тоо:

	Хэлэлцсэн төслийн нэр	Төслийн саналыг дэмжсэн иргэдийн тоо
1		
2		
3		
4		
...		

Санал асуулга эхэлсэн хугацаа

Санал асуулга дуусгавар болсон хугацаа

Санал асуулгад оролцогчдын жагсаалтыг хавсаргана.

Танилцаж хүлээн авсан Засаг даргын гарын үсэг:/...../

20... оны...сарын ... өдөр

Цахим хэлбэрээр санал өгөх /ОНХС аппликэйшн, И-монголиа/

- Цахим хэлбэрээр санал авахдаа 30-аас доошгүй хоногийн турш тогтсон цахим хаяг, цахим хуудас, гар утасны программ ашиглан санал өгч буй иргэний баталгаажуулах боломжтойгоор иргэдийн саналыг хүлээн авна.
- Саналыг 1-6 дугаар сарын хугацаанд ИНХ-ын хуралдаан хуралдахаас өмнө авч ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 4 дүгээр хавсралт маягтын дагуу нэгтгэн баталгаажуулна.
- Аппликэйшн 2022 оноос ашиглалтад орж байгаа ба интернэтийн сүлжээ орж болох бүх газар гар утсандаа татаж суулгаж саналаа өгнө.
- Аппликэйшнээс ОНХС-ийн мэдээлэл авч, санал гомдлыг өгч болно.



ОНХС-ийн Иргэдийн нийтийн хурлын хуралдаанд заавал оролцох


- Баг/хорооны ИНХ-ын хуралдааныг 6 дугаар сард багтаж хуралдуулдаг;
- Санал асуулгын хуудасны иргэнд үлдэх хэсэгт ИНХ-ын хуралдааны товыг бичсэн байдаг;
- Баг/хорооны иргэдийн гаргасан бүх саналыг нэгтгээд ИНХ-аараа санал тус бүрээр хэлэлцэн, баталдаг тул ИНХ-ын хуралдаанд оролцох нь чухал үе шат юм.
- Хуралдааны шийдвэр/жагсаалт/, тэмдэглэлийг баг/хорооны Засаг даргад өгнө.



ОНХС-ийн санал хэлэлцэх, батлах ИНХ-ын хуралдааныг хэрхэн зохион байгуулах заавар видео үзэх бол [ЭНД](#) дарна уу.

Ажлын хэсэг саналуудыг нэгтгэж, эрэмбэлэх үе шат


- Баг/хорооны ЗД ИНХ-ын тогтоол/жагсаалт/, хурлын тэмдэглэл, санал тус бүрийн төслийн дэлгэрэнгүй танилцуулгын хамт Сум/дүүргийн ОНХС-ийн санал нэгтгэх, эрэмбэлэх “**Ажлын хэсэг**”-т **6 сарын 31-ий** дотор хүргүүлнэ;
- “Ажлын хэсэг” **7-р сард багтаж** баг/хороодын саналыг нэгтгэж эрэмбэлнэ/эрэмбэлэх аргыг гарын авлагаас үзнэ/;
- **Алслагдсан** баг/хорооны саналыг заавал багтаана;
- Нэгтгэж, эрэмбэлээд Сум/дүүргийн **ЗД-ын зөвлөлийн хуралд** танилцуулна.



Ажлын хэсэг саналуудыг нэгтгэж, эрэмбэлэх үе шат

Сум/дүүргийн ажлын хэсэг нэгтгэж, эрэмбэлэхдээ дараах шалгуурыг харгалзана:

- Баг/хороодоос ирүүлсэн санал нь иргэдийн олонхын саналаар дэмжигдсэн эсэх;
- Сум/дүүргийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн тэргүүлэх чиглэл болон газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдсан эсэх;
- ОНХС-аар хэрэгжүүлэхгүй, хасагдах хөрөнгө оруулалт байгаа эсэх;
- Урьдчилсан тооцсон төсөвт өртгийг үр өгөөж хүртэгчдийн тоонд харьцуулсан төсөвт өртгийн харьцаа зэргийг харгалзаж эрэмбэлнэ.



Саналыг ИТХ-аар батлах, хэрэгжүүлэх үе шат



- 12 дугаар сард төсөв батлах үеэр ОНХС-ийн саналуудыг ИТХ-ын хуралдаанаар баталдаг;
- Сум/Дүүргийн ИТХ нь зөвхөн иргэдийн саналаар гарсан хөрөнгө оруулалтын саналуудыг баталдаг;
- ИТХ-аар батлагдсан саналын жагсаалтыг дараа онд хэрэгжүүлдэг;
- Хэрэгжилт нь Худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн дагуу хийгддэг.



Иргэдийн хяналт



Сум/дүүргийн ЗДТГ, баг/хорооны Засаг дарга, www.onhs.mof.gov.mn сайтаас



ИТХ, ЗДТГ-тай хамтран ХШҮ хийхэд оролцох

Иргэн хэрэгжиж буй ажилд бие даан хяналт тавих

Иргэний нийгмийн байгууллагатай хамтарч ХШҮ хийх



ОНХС-ийн Удирдлагын мэдээллийн систем - www.onhs.mof.gov.mn


ОНХС-ийн
төсөв

Иргэдийн
санал

Батлагдсан
жагсаалт

Хийгдсэн
ажил

Гомдол, санал
өгөх




Газрын зургаас амьдарч буй сум/дүүргээ сонгож дараад ОНХС-ийн мэдээллийн үзээрэй!

Мэдээлэл авах эх сурвалжууд

- **ОНХС-ийн цахим хуудас:**
www.tusuv-oronnutag.mof.gov.mn
- **ОНХС-ийн Фэйсбүүк пэйж:**
www.facebook.com/LDFMongolia
- **ОНХС-ийн Фэйсбүүк групп:**
Орон нутгийн хөгжлийн сангийн нэгдсэн бүлэг
- **ОНХС-ийн Твиттер хуудас:**
www.twitter.com/LDFMongolia
- **ОНХС-ийн Youtube хуудас:**
Орон нутгийн хөгжлийн сан
- **Манай сумын мэдээлэл авах эх үүсвэр:**
www.facebook.com/.....

ОНХС-ийн Удирдлагын мэдээллийн систем

Санал, гомдол өгөх



The screenshot shows the website of the National Center for Regional Development of Mongolia. The header features logos of partner organizations including the Mongolian State, the Ministry of Development and Economic Cooperation, The World Bank, and the Swiss Agency for Development and Cooperation SDC. The main navigation bar includes links for 'НҮҮР', 'ОНХС-ийн тухай', 'зохицуулалт', 'ОНХС ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ', 'мэдээ, мэдээлэл', 'ТОГТВОРТОЙ АМЬЖИРГАА-3 ТӨСӨЛ', and 'САНАЛ, ХҮСЭЛТ, ГОМДОЛ'. Two red arrows point from the text above to the 'ОНХС ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ' and 'САНАЛ, ХҮСЭЛТ, ГОМДОЛ' links. The main content area features a large banner with the text 'ИРГЭН ТА ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр хийх ажилд САНАЛ өгөх эрхтэй' and a news article titled '2022 онд ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНД 253 ТЭРБУМ ТӨГРӨГ ХУВААРИЛАГДАНА'. A sidebar on the right contains a section titled 'ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН ГЭЖ ЮУ ВЭ?' with a detailed description of the center's mission and a 'Дэлгэрэнгүй' link.



ОРОН НУТГИЙН
ХӨГЖЛИЙН
САН



Орон нутгийн хөгжлийн сан



<http://tusuv-oronnutag.mof.gov.mn/>



Орон нутгийн хөгжлийн сан



ОРОН НУТГИЙН
ХӨГЖЛИЙН
САН

Иргэн бүр **6 сарын 31** -ээс өмнө **ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН**-д саналаа өгч,
ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРАЛДАА ОРОЛЦОЦГООЁ!



ТАНЫ ОРОЛЦОО - НУТГИЙН ХӨГЖИЛ